



ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС












БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2018 оны эхний 1 сард



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2014-2018 ОН	3
 АЖ ҮЙЛДВЭР	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД	8
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	9
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	13
 ҮНЭ ХАНШ	14

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2017 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		1	2	3	4	5
Нийт мал	172049	42856	11964	43683	47027	26519
Үүнээс:						
Тэмээ	224	70	-	152	2	-
Адуу	13391	3882	696	3354	3092	2367
Үхэр	14563	3947	1221	3344	3631	2420
Хонь	88526	21268	6129	22426	25634	13069
Ямаа	55345	13689	3918	14407	14668	8663

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014.I	2015.I	2016.I	2017.I	2018.I
Суурин хүн ам	тоо	28333	28419	28973	28787	
Төрөлт	тоо	62	53	31	36	45
Нас баралт	тоо	14	14	11	10	12
Шилжиж ирсэн	тоо	78	83	95	74	65
Шилжиж явсан	тоо	96	73	94	99	93
Цэвэр өсөлт	хувь	0.17	0.14	0.07	0.09	0.11'
Механик өсөлт	хувь	-0.06	0.04	0.00	-0.09	-0.10'

' – өмнөх оны суурин хүн амаас тооцов



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2018 оны эхний 1 сард 16.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.7 (11.2 %) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2017.I	2018.I	$\frac{2018}{2017}$ %	2017.I	2018.I	$\frac{2018}{2017}$ %
Нүүрс олборлолт	м.тн	487.7	541.2	111.0	14 387.2	15 965.4	111.0
Дулаан дамжуулалт	м.гкал	26.8	30.4	113.4	725.8	828.5	114.1
Талх үйлдвэрлэлт	тн	11.2	11.5	102.7	15.8	16.1	101.9
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	7.9	11.1	140.5	31.1	48.5	155.9

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн биет хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 53.5 (11.0%) мянган тонноор, дулаан дамжуулалт 3.6 (13.4%) мянган гкалаар, талх үйлдвэрлэлт 0.3 (2.7%) тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 3.2 (40.5%) тонноор тус тус өссөн байна.


Зураг 1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар



Зураг 2. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, мянган төгрөг



Зураг 3. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн 1 сард



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 1578.2 (11.0%) сая төгрөгөөр, дулаан дамжуулалт 102.7 (11.4%) сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 0.3 (1.9%) сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 17.4 (55.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 оны эхний 1 сард нийгмийн даатгалын сангийн орлого 1557.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 416.1 (36.5%) сая төгрөгөөр өссөн бол зарлага 1620.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 189.5 (10.5%) сая төгрөгөөр буурсан байна.

Нийт орлогын 959.3 (61.6%) сая төгрөг тэтгэврийн сангаас, 109.0 (7.0%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 168.5 (10.8%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 295.6 (19.0%) сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 25.2 (1.6%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017. I	2018. I	$\frac{2018.I}{2017.I}$ %
Сангийн орлого, бүгд	1141.5	1557.6	136.5
тэтгэврийн сан	703.0	959.3	136.5
тэтгэмжийн сан	79.0	109.0	138.0
ажилгүйдлийн сан	19.1	25.2	131.9
ҮОМШӨ-ний сан	123.7	168.5	136.2
ЭМД-ын сан	216.7	295.6	136.4
Сангийн зарлага, бүгд	1809.6	1620.1	89.5
тэтгэврийн сан	1301.1	1370.0	105.3
тэтгэмжийн сан	71.4	95.8	134.2
ҮОМШӨ-ний сан	146.5	127.3	86.9
ЭМД-ын сан	252.0	-	-
ажилгүйдлийн сан	38.6	27.0	69.9

Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4108 хүнд 1370.0 сая төгрөгийн тэтгэвэр, 304 хүнд 95.8 сая төгрөгийн тэтгэмж, 247 хүнд 127.3 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 16 хүнд 27.0 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2018 оны эхний 1 сард нийгмийн халамжийн сангийн орлого 462.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 277.4 (1.5 дахин) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 183.5 (39.7%) сая төгрөг улсын төсвөөс, 277.7 (60.0%) сая төгрөг орон нутгийн төсвөөс, 1.2 (0.3%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

Зураг 6. Нийгмийн халамжийн сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 443 хүнд 65.7 сая төгрөгийн тэтгэвэр, 350 хүнд 32.4 сая төгрөгийн тэтгэмж, 260 жирэмсэн эхчүүдэд 11.6 сая төгрөгийн тэтгэмж, 849 ахмадуудад 70.8 сая төгрөгийн насны хишиг олгосон байна.

Ахмад дайчин, гавьяат цолтой 12 хүнд 2.0 сая төгрөг, 120 ахмад настанд 17.2 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, 2697 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 33.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 60 иргэдэд 4.5 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал, сая төгрөг

Үзүүлэлт	2017. I	2018. I	$\frac{2018.I}{2017.I}$ %
Сангийн орлого	185.0	462.4	2.5*
Улсын төсвөөс	6.0	183.5	30.6*
Орон нутгийн төсвөөс	178.8	277.7	155.3
Бусад орлого	0.2	1.2	6.0*
Сангийн зарлага	131.7	280.8	2.1*
Тэтгэвэр	63.0	65.7	104.3
Тэтгэмж	27.4	32.4	118.2
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	22.4	11.6	51.8
Насны хишиг	-	70.8	-
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	1.6	2.0	125.0
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	3.3	17.2	5.2*
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	1.3	4.5	3.5*
“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	12.6	33.0	2.6*
Цалинтай ээж	-	43.5	-
Бусад үйлчилгээ	0.1	0.1	100.0


*дахин их



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


2018 оны 1 сарын эцэст дүүргийн хэмжээнд ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 389 бүртгэгдсэний 212 (54.5%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 7. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн



Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 89 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 43 (48.3%) нь эмэгтэйчүүд байна. Мөн энэ хугацаанд 21 иргэн ажилд зуучлуулан орсон ба хувьцаат компанид 4, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 9, төсөвт байгууллагад 7, улсын үйлдвэрийн газарт 1 иргэн тус тус ажилд орсон байна.

Зураг 8. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн 81 (20.8%) нь 16-24 насны, 144 (37.0%) нь 25-34 насны залуучууд, 79 (20.3%) нь 35-44 насныхан, 75 (19.3%) нь 45-60 насны, 10 буюу (2.6%) нь 60-аас дээш насны ажилгүй иргэд байна.

Ажил идэвхтэй хайж буй иргэдийн 102 (26.2%) нь дээд боловсролтой, 22 (5.7%) нь тусгай дунд боловсролтой, 27 (6.9%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 224 (57.6%) нь бүрэн дунд боловсролтой, 10 (2.6%) нь бүрэн бус дунд боловсролтой, 4 (1.0%) нь бага болон боловсролгүй ажээ.




ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2018 оны эхний 1 сард 52 эх амаржиж, 53 хүүхэд төрүүлснээс бусад аймаг орон нутаг, дүүргийн харьяат 16 эх амаржсан байна. Энэ хугацаанд 19996 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1629 (8.8%) хүнээр, 798 хүн хэвтэн эмчлүүлсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 19 (2.4%) хүнээр тус тус өссөн байна.

Хүснэгт 6. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2017. I	2018. I	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	19	23	4
Заг хүйтэн	9	10	1
Тэмбүү	6	5	-1
Мөөгөнцөр /кандидоз/	-	1	1
Трихомониаз	4	5	1
Кандилом	-	2	2
Цочмог халдварт өвчин	32	24	-8
Гепатит А	1	2	1
Салхин цэцэг	26	19	-7
Хачигт рикеттиоз	1	-	-1
Рож	1	-	-1
Гар хөл амны өвчин	-	1	1
Сүрьеэ	3	2	-1
Нийт халдварт өвчин	51	47	-4

Зураг 9. Халдварт өвчин, сараар




2018 оны эхний 1 сард халдварт паразит өвчний 23 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 48.9%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 (21.1%) тохиолдлоор өссөн бол цочмог халдварт өвчний 24 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 51.1%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 8 (25.0%) тохиолдлоор буурсан байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 16.2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.5 продицмиллээр буурчээ.



ГЭМТ ХЭРЭГ

2018 оны эхний 1 сард дүүргийн хэмжээнд 34 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17 (2 дахин) хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 8.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 58.7 пунктээр доогуур байна.

Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар




Хүснэгт 7. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2017.I	2018.I	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	17	34	17	100.0	100.0
Хүний амь нас хохироох	-	-	-	-	-
Хүний амь нас хохирсон	-	1	1	-	2.9
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	10	16	6	60.0	47.1
Гэр бүлийн хүчирхийлэл	-	1	1	-	2.9
Бэлгийн халдашгүй байдал	-	1	1	-	2.9
Бусдын эд хөрөнгө хулгайлах	5	4	-1	-20.0	11.8
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	-	-	-	-
Залилан мэхлэх	-	2	2	-	5.9
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	1	1	-	2.9
Эд хөрөнгө устгах гэмтээх	-	2	2	-	5.9
Мал хулгайлах	-	2	2	-	5.9
Мөнгөн тэмдэгт хуурамчаар бэлтгэх	-	2	2	-	5.9
Орчиндоо аюул учруулах, амьтныг зохих хамгаалалтгүй орхих	1	-	-1	-	-
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	1	1	-	2.9
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	1	1	-	-	2.9
Хэрэг илрүүлэлтийн хувь	66.7	8.0			

Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнхийг буюу 47.1 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 11.8 хувийг бусдын эд хөрөнгө хулгайлах хэргүүд эзэлж байна. Тайлант хугацаанд залилан мэхлэх, эд хөрөнгө устгах гэмтээх хэрэг, малын хулгайн хэрэг, мөнгөн тэмдэгт хуурамчаар бэлтгэх хэрэг тус бүр 2, хүний амь нас хохирсон

хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн халдашгүй байдлын хэрэг, гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх, хууль сахиулагчийг эсэргүүцэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.


Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Хүснэгт 8. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2017.I		2018.I	
	согтуугаар	гудамж талбайд	согтуугаар	гудамж талбайд
Бүгд	8	5	18	7
Хүний амь нас хохирсон	-	-	-	1
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	8	3	15	3
Гэр бүлийн хүчирхийлэл	-	-	1	-
Бэлгийн халдашгүй байдал	-	-	1	-
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	1	-	-
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	-	-	1
Эд хөрөнгө устгах гэмтээх	-	-	-	1
Орчиндоо аюул учруулах, амьтныг зохих хамгаалалтгүй орхих	-	1	-	-
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	-	1	1
Дүнд эзлэх хувь	47.1	29.4	52.9	20.6


Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний 1 сард



Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 18 болж өмнөх оны мөн үеэс 10 (2.2 дахин) хэргээр, гудамж талбайд 7 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 (40.0%) хэргээр тус тус өссөн байна.

Харин согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 52.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.8 пунктээр нэмэгдсэн бол гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 20.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.8 пунктээр доогуур байна.

Зураг 13. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн эхний 1 сард






НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 135.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.9 (3.7%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 108.3 (79.7%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 9. Орон сууц нийтийн аж ахуйн орлого, сая төгрөг

Үзүүлэлт	2017.I	2018.I	Өсөлт бууралт
Нийт орлого	130.9	135.8	4.9
Орон сууц	16.4	16.2	-0.2
Ус борлуулалт, бүгд	59.7	61.7	2
хүн амд	36.5	34.1	-2.4
аж ахуйн нэгжид	22.5	26.8	4.3
үйлчилгээний байгууллагад	0.7	0.7	0
Сувагжуулалт	46.2	47.6	1.4
Бусад	8.8	10.3	1.5

Зураг 14. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 10. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт, мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
Нийт дүн	37485.8	38203.1	101.9
Үүнээс:			
Тавлаг өргөө	6835.0	5953.1	87.1
Маргад өргөө	6609.0	8401.7	127.1
Сод хөгжил	8426.1	8115.6	96.3
Шинэ элч	7624.4	7474.5	98.0
Уурхайчин	4140.0	6011.4	145.2
Содон суварга	3851.3	2246.8	58.3




ҮНЭ ХАНШ

2018 оны 1 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2018 оны 1 сарын дундаж үнэ

№	Хүнсний бараа		Хэмжих нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	В&М супер маркет	Шинэ зах	
1	"Алтан тариа" гурил	Дээд	кг	1400	1300		1300	1300	
		I зэрэг	кг	1100	1100		1100	1100	
		II зэрэг	кг	900	900		900	900	
2	Будаа	цагаан	кг	2350	2100		2200	2300	
		шар	кг	1200	1200		1200	1200	
3	Хонины мах	ястай	кг			5375		5375	
		цул	кг			6375		6375	
4	Үхрийн мах	ястай	кг			6875		6875	
		цул	кг			7875		7875	
5	Адууны мах, ястай		кг			5500		5500	
6	Ямааны мах		кг			4000		4000	
7	Элсэн чихэр		кг	2150	2200		2300	2200	
8	Сүү /задгай/		л	2250					
9	Тараг /задгай/		л	-					
10	Цөцгийн тос, Орос		кг	3500	3400		3400		
11	Байцаа		кг			1500	1500	1500	
12	Манжин		кг			3000	3000	3000	
13	Төмс	монгол	кг			900	900	900	
14	Лууван	монгол	кг			1500	1500	1500	
15	Сонгино	хятад	кг			1200	1200	1200	
		монгол	кг			3000	3000	3000	
16	Сармис, булцуу		ш			500	500	500	
17	Огурцы, хятад		кг			5000	5000	5000	
18	Помидор, хятад /үрлэн/		кг			6000	6000	6000	
19	Ургамлын тос/ sunny gold/		ш	3550	3450		3500	3500	
20	Өндөг		ш	380	350		350	330	
21	Талх	буриад	том 900 гр	ш	1600	1600		1600	1600
			Дунд 700 гр	ш	1400	1400		1400	1400
			жижиг 500 гр	ш	1100	1100		1100	1100
		Есөн шанд /дунд/		ш	1500	1500		1500	1500
		Атар талх		ш	1200	1200		1200	1200

Зураг 15. “Алтан тариа” гурилын үнэ, жил бүрийн 1-р сард



Зураг 16. Нэг кг цул махны үнэ, жилийн бүрийн 1-р сард



Хүснэгт 12. Үйлчилгээний үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжин нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Дулаан	1м ²	600	1м ³	983
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000		
	40м ² - 80м ²	5 000	-	-
	81м ² -аас дээш	10 000		
Халуун ус	Өвөл 1 хүн (тоолуургүй)	2 875	1 гкал	69 647
	1м ³ (тоолууртай)	1 484		
	Зун 1 хүн (тоолуургүй)	4 025		
	1м ³ (тоолууртай)	1 484		
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	0.8	1 л (тоолуургүй)	1.50
	1 л (тоолууртай)	0.65	1 л (тоолууртай)	1.20
	суурь хураамж	1 800	1 л (зөөврөөр)	5.45
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	0.77	1 л (тоолуургүй)	1.50
	1 л (тоолууртай)	0.63	1 л (тоолууртай)	1.20

*2017 оны 9 сарын 15-наас мөрдөж байгаа тариф

Хүснэгт 13. Цахилгааны үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	98.4
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	118.2
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	104.3
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	77.1
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	128.5
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	209.8
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1
3 тарифт тоолууртай /уул уурхай, үйлдвэрийн газар/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1


* 2015 оны 7 сарын 25-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 14. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2015. I	2016. I	2017. I	2018. I	Өөрчлөлт	
					төгрөг	хувь
АИ -76,80	1560	1440	1440	1508	68	4.7
АИ -92,93	1700	1540	1540	1654	114	7.4
Дизель түлш	1830	1650	1650	1781	131	7.9

2018 оны 1 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд АИ-80 бензин 68 төгрөгөөр (4.7), АИ-92 бензин 114 төгрөгөөр (7.4), дизель түлш 131 төгрөгөөр (7.9) тус тус өссөн байна.


Зураг 17. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ, (чиглэл: УБ-БН, БН-



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
МОНСТАТ аппликейшн



Download on the
App Store

Google play



Утсаар:



Лавлах утас

1900-1212